



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/117/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Миндүг Аудит ХХК
Гүйцэтгэх захирал С.Энхтөр
Утас: 95957791
Цахим хаяг: director@mindug.mn

Аудитын менежер Ц.Номингоо
Утас: 90098901
Цахим хаяг: соо@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

| | |
|---|----|
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 5 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 10 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа | 10 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 11 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд..... | 11 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 12 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 13 |
| 4.1 Ерөнхий зүйл | 13 |
| 4.2 Материаллаг байдал | 13 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 14 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 14 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 14 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 15 |
| 4.5.1 Завсрын аудитын талаар | 15 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 15 |
| 5.1 Төлбөрийн акт | |
| 5.2 Албан шаардлага | |
| 5.3 Зөвлөмж | 15 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 16 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|--|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий Аудитор |
| ЗДТГ | Засаг Даргын Тамгын Газар |
| БигГ | Гаалийн ерөнхий газрын харьяа Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| УТХО | Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ХХК | Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани |



**СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

**СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР
СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ж.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА**

2023.08.25 № 111
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 163,994.0 мянган төгрөг буюу 25 хувиар өссөн нь 137,567,5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 10,168.9 мянган төгрөгийн үнэ төлбөргүй бараа материал аймгийн ЗДТГ-аас хандив, тусламжаар өгч, Засгийн газрын 107 дугаар тогтоол, БШУ-ны сайдын А/122 тоот тушаалаар цалин хөлсний хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой нөлөөлсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Үйл ажиллагааны тайлан, бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|------------------------------|------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>61,134,210.00</u> | <u>77,815,032.72</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | - |
| 33 | АВЛАГА | 744,176.00 | 2,479,018.72 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 2,479,018.72 |
| 335 | Бусад авлага | 744,176.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 744,176.00 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 60,390,034.00 | 75,336,014.00 |
| 354 | Хангамжийн материал | 60,390,034.00 | 75,336,014.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 6,500,000.00 | 6,919,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 466,018.00 | 375,835.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 53,424,016.00 | 68,041,179.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>315,367,575.01</u> | <u>436,247,227.20</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 315,367,575.01 | 436,247,227.20 |
| 392 | Биет хөрөнгө | 307,873,575.01 | 415,101,227.20 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 311,985,280.68 | 437,200,767.68 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (42,756,300.72) | (60,544,256.47) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 77,298,214.00 | 79,103,714.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (70,380,221.80) | (63,375,721.88) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 88,755,000.00 | 56,293,900.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (60,523,473.93) | (35,973,175.89) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 31,734,174.00 | 31,734,174.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (29,625,097.22) | (30,724,174.24) |
| 39217 | Ном | 1,386,000.00 | 1,386,000.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 7,494,000.00 | 21,146,000.00 |
| 39301 | Програм хангамж | - | 1,500,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - | (200,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 7,494,000.00 | 19,846,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>376,501,785.01</u> | <u>514,062,259.92</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>741,129.00</u> | <u>5,296,704.00</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 741,129.00 | 5,296,704.00 |
| 413 | Өглөг | 741,129.00 | 5,296,704.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 741,129.00 | 3,796,704.00 |
| 4136 | Бусад өглөг | - | 1,500,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 1,500,000.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>375,760,656.01</u> | <u>508,765,555.92</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 375,760,656.01 | 508,765,555.92 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 190,813,370.00 | 190,813,370.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 190,813,370.00 | 190,813,370.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 112,059,757.56 | 245,064,657.47 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 61,523,996.14 | (263,697,851.45) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 50,535,761.42 | 508,762,508.92 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 72,887,528.45 | 72,887,528.45 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>376,501,785.01</u> | <u>514,062,259.92</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 491,103,516.00 | 1,030,855,155.52 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 78,246,016.00 | 523,493,996.01 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 78,246,016.00 | 523,493,996.01 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 78,246,016.00 | 523,493,996.01 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 78,246,016.00 | 523,493,996.01 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 412,857,500.00 | 507,361,159.51 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 385,350,900.00 | 451,224,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 451,224,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 385,350,900.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 160,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 160,000.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 27,346,600.00 | 56,137,059.51 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 27,346,600.00 | 56,137,059.51 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 440,567,754.58 | 521,740,979.75 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 440,567,754.58 | 521,740,979.75 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 436,467,799.58 | 516,245,379.75 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 292,554,780.00 | 326,020,435.51 |
| 210101 | Үндсэн цалин | 187,294,714.03 | 235,891,871.68 |
| 210102 | Нэмэгдэл | 75,677,456.96 | 72,059,566.10 |
| 210104 | Урамшуулал | 29,582,609.01 | 18,068,997.73 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 38,889,600.00 | 46,334,881.28 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,366,800.00 | 30,714,581.28 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,880,800.00 | 3,905,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,304,500.00 | 3,124,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 576,100.00 | 781,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,761,400.00 | 7,810,300.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 25,087,729.00 | 26,563,805.24 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,483,971.00 | 4,001,136.24 |
| 210302 | Түлш, халаалт | 22,028,258.00 | 21,533,669.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 575,500.00 | 1,029,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,508,000.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 402,600.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 650,000.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 116,000.00 | - |
| 210404 | Ном, хэвлэл | 92,900.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 246,500.00 | - |
| 2105 | Нормативт зардал | 34,368,862.00 | 70,223,687.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,802,500.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 29,888,352.00 | 70,223,687.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,678,010.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,926,889.00 | 3,908,965.76 |
| 210604 | Урсгал засвар | 2,926,889.00 | 3,908,965.76 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 117,000.00 | - |

| | | | |
|-------------|--|-----------------------------|------------------------------|
| 210702 | Дотоод албан томилолт | 117,000.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,061,600.00 | 962,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,061,600.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 962,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 36,953,339.58 | 42,231,604.96 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 893,000.00 | 7,274,537.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,663,300.00 | 3,840,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 33,397,039.58 | 31,117,067.96 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,099,955.00 | 5,495,600.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 3,500,000.00 | 5,495,600.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 3,500,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 5,495,600.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 599,955.00 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 599,955.00 | - |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>50,535,761.42</u> | <u>509,114,175.77</u> |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 351,666.85 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 351,666.85 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - | (351,666.85) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>50,535,761.42</u> | <u>508,762,508.92</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|------------------------------|------------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>412,857,500.00</u> | <u>507,361,159.51</u> |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 412,857,500.00 | 507,361,159.51 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 385,350,900.00 | 451,224,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 451,224,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 385,350,900.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 160,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 160,000.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 27,346,600.00 | 56,137,059.51 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 27,346,600.00 | 56,137,059.51 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>407,357,500.00</u> | <u>494,080,259.51</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 407,357,500.00 | 494,080,259.51 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 403,257,545.00 | 488,584,659.51 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 292,272,500.00 | 325,276,259.51 |
| 210101 | Үндсэн цалин | 187,012,434.03 | 235,147,695.68 |
| 210102 | Нэмэгдэл | 75,677,456.96 | 72,059,566.10 |
| 210104 | Урамшуулал | 29,582,609.01 | 18,068,997.73 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 38,889,600.00 | 48,813,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,366,800.00 | 33,193,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,880,800.00 | 3,905,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,304,500.00 | 3,124,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 576,100.00 | 781,000.00 |

| | | | |
|-------------|--|-----------------------|------------------------|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,761,400.00 | 7,810,300.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 24,346,600.00 | 27,304,934.24 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,483,971.00 | 4,001,136.24 |
| 210302 | Түлш, халаалт | 21,287,129.00 | 22,274,798.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 575,500.00 | 1,029,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,508,000.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 402,600.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 650,000.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 116,000.00 | - |
| 210404 | Ном, хэвлэл | 92,900.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 246,500.00 | - |
| 2105 | Нормативт зардал | 35,505,945.00 | 66,336,800.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,802,500.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 30,969,145.00 | 66,336,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,734,300.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,000,000.00 | 3,908,965.76 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 3,908,965.76 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 117,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 117,000.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,061,600.00 | 962,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,061,600.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 962,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,556,300.00 | 15,981,800.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 893,000.00 | 12,141,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,663,300.00 | 3,840,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,099,955.00 | 5,495,600.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 3,500,000.00 | 5,495,600.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 3,500,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 5,495,600.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 599,955.00 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 599,955.00 | - |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 5,500,000.00 | 13,280,900.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 5,500,000.00 | 13,280,900.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 5,500,000.00 | 13,280,900.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 5,500,000.00 | 13,280,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 5,500,000.00 | 13,280,900.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (5,500,000.00) | (13,280,900.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь |
|-----|----------|---------------------------------|-----------------------|-------------------|---------------------|
|-----|----------|---------------------------------|-----------------------|-------------------|---------------------|

| | | | | | оролцооний нийт дүн |
|-----|--|-----------------------|----------------------|------------------------|------------------------|
| C01 | 2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C08 | 2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D01 | 2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 190,813,370.00 | 72,887,528.45 | 112,059,757.56 | 375,760,656.01 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | -375,757,609.01 | -375,757,609.01 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 190,813,370.00 | 72,887,528.45 | -263,697,851.45 | 3,047.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 508,762,508.92 | 508,762,508.92 |
| D09 | 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 190,813,370.00 | 72,887,528.45 | 245,064,657.47 | 508,765,555.92 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|---|-----------------------|----------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 509,846,300.00 | 507,361,159.51 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 509,846,300.00 | 507,361,159.51 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 504,350,700.00 | 501,865,559.51 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 325,276,300.00 | 325,276,259.51 |
| 210101 | Үндсэн цалин | 264,751,200.00 | 235,147,695.68 |
| 210102 | Нэмэгдэл | 51,695,700.00 | 72,059,566.10 |
| 210104 | Урамшуулал | 8,829,400.00 | 18,068,997.73 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 48,813,900.00 | 48,813,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,193,600.00 | 33,193,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,905,000.00 | 3,905,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,124,000.00 | 3,124,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 781,000.00 | 781,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,810,300.00 | 7,810,300.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 28,699,000.00 | 27,304,934.24 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,000,000.00 | 4,001,136.24 |
| 210302 | Түлш, халаалт | 23,199,400.00 | 22,274,798.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,499,600.00 | 1,029,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 66,336,800.00 | 66,336,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 66,336,800.00 | 66,336,800.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 16,900,000.00 | 15,808,965.76 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 11,900,000.00 | 11,900,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 3,908,965.76 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 962,000.00 | 962,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 962,000.00 | 962,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,362,700.00 | 17,362,700.00 |

| | | | |
|-------------|---|----------------|----------------|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,522,700.00 | 13,522,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,840,000.00 | 3,840,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,495,600.00 | 5,495,600.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 5,495,600.00 | 5,495,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,495,600.00 | 5,495,600.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 514,291,300.00 | 507,361,159.51 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 514,291,300.00 | 507,361,159.51 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 514,291,300.00 | 507,361,159.51 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа явуулдаг БШУ-ны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын чиг үүрэг нь хүүхэд нэг бүрийн бие сэтгэл, эрүүл мэндийг эрхэмлэн, тоглох явцдаа өөрсдийн хүсэл сонирхлыг бүтээлчээр илэрхийлдэг, сурч мэдэх хүсэл эрмэлзэлтэй, би чадна гэсэн итгэлтэй болгон хөгжүүлнэ.

Хүүхдийн нийгэм сэтгэл зүй, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, боловсрол эзэмшихэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж, сурах тэгш боломж бүрдүүлэх, хувь хүний онцлогт нийцүүлэн сургалт, үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах, хамтран суралцах арга барилыг сургалтад нэвтрүүлэх зорилго дэвшүүлэн ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2022 оны 3 сарын 9-ний өдрийн 107 тоот тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”
- Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан тоот “Төсвийн тухай хуулийн дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах”
- БШУ-ны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/122 тоот тушаал “Төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай”
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө дунд зэрэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах/ шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 137,560.5 мянган төгрөгөөр буюу 36.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | /мянган төгрөгөөр/ | | |
|--|--------------------|-------------------|-------------------|
| | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 744.18 | 2,479.02 | 1,734.84 |
| Бараа материал | 60,390.03 | 75,336.01 | 14,945.98 |
| Үндсэн хөрөнгө | 315,367.58 | 436,247.23 | 120,879.65 |
| Нийт хөрөнгө | 376,501.79 | 514,062.26 | 137,560.47 |
| Өр төлбөр | 741.13 | 5,296.70 | 4,555.58 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 375,760.66 | 508,765.56 | 133,004.90 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 376,501.79 | 514,062.26 | 137,560.47 |

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 436,247.2 мянган төгрөг болж, 120,879.6 мянган төгрөгөөр буюу 38.3 хувиар өссөн нь 48,995.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хандиваар авсан, 76,219.9 мянган төгрөгийн хөрөнгө орлогод авсан нь нөлөөлжээ.

Бараа материалын үлдэгдэл 75,336.0 мянган төгрөг болж 14,945.9 мянган төгрөгөөр буюу 24.75 хувиар өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 539,751.6 мянган төгрөг буюу 109.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орлого байна. Энэ нь Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан бичиг хүргүүлсний дагуу гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэн авч нэгтгэхтэй

холбоотой санхүүгийн үр дүнгийн өмчийн өөрчлөлтийн тайлан дээрх үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлээс хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийг хассан зөрүүг үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /үндсэн хөрөнгө/, бараа материалын эхний үлдэгдлийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /бараа материал/ дээр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 81,173.2 мянган төгрөгөөр буюу 18.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардал нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил, хоол хүнстэй холбоотой зардал байна. Цалингийн зардал 33,465.6 мянган төгрөгөөр буюу 11.4 хувиар өссөн нь Засгийн газрын 2022 оны 3 сарын 9-ний өдрийн 107 тоот тогтоол, БШУ-ны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/122 тоот тушаал, хоол хүнсний зардал 40,335.3 мянган төгрөгөөр буюу 135 хувиар өссөн нь Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын хэрэгжилттэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 717,266.6 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 15,006.8 мянган төгрөг, нийт зарлагыг 977,963.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн 26 арга хэмжээг санхүүжүүлэхэд 509,846.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 507,361.2 мянган төгрөг мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр, үйл ажиллагааны орлогоос 2,485.1 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант хугацаанд 9 төсөл, хөтөлбөр 26 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 99.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

| Д/д | Хөтөлбөр арга хэмжээ | Төлөвлөгөө | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|-----|----------------------|---|------------|------------|-------|---------|
| 1 | 81605 | Эрүүл мэндийг дэмжих | 1,300.00 | 1,300.00 | - | 100% |
| 2 | 81807 | Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 66,336.80 | 66,336.80 | | 100% |
| 3 | 81816 | Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр | 2,683.50 | 2,683.50 | - | 100% |
| 4 | 81823 | Боловсролын байгууллагын багш ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх хөтөлбөр | 1,300.00 | 1,300.00 | - | 100% |
| 5 | 81834 | Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөтөлбөр | 336,836.20 | 336,836.20 | - | 100% |
| 6 | 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах | 42,767.60 | 42,767.60 | - | 100% |
| 7 | 83201 | Ангилалдаагүй бусад зориулалт арга хэмжээ | 11,900.00 | 11,900.00 | - | 100% |

| | | | | | | |
|---|-------|---------------------------|-------------------|-------------------|-----------------|-------|
| 8 | 80112 | Нийтлэг үйлчилгээ | 13,023.20 | 13,023.20 | - | 100% |
| 9 | 80111 | Байр ашиглалтын үйлчилгээ | 33,699.00 | 31,213.90 | 2,485.10 | 93% |
| | | | 509,846.30 | 507,361.20 | 2,485.10 | 99.2% |

Батлагдсан төсөв гүйцэтгэлийн зөрүү 2,485.1 мянган төгрөг олгогдоогүй санхүүжилтийн дүн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилт аваагүй, туслах үйл ажиллагааны хүрээнд орлого бүрдүүлээгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Миндүг Аудит” ХХК-ны /МНБ, аудитор/ С.Энхтөр, аудиторын туслах М.Уламбаяр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Б.Бүзмаа Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, тус газрын Дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр

дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов..

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.5 хувиар буюу 6,608.5 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,956.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд батлагдсан төсвөөс хэтэрсэн зардал байхгүй, хэмнэлттэй ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын цэцэрлэг нь 2022 онд нийт 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулахаас 94 мэдээллийг хугацаандаа мэдээллэсэн, 12 мэдээллийг хугацаа хоцроосон, 13 мэдээллийг байршуулаагүй зөрчилтэй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын цэцэрлэгт завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 191,273.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 744.2 мянган төгрөгийн төлбөрийн зөрчилд акт тогтоож, төлбөрийг бүрэн барагдуулж биелүүлсэн.

Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 21 нэр төрлийн 190,529.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох эрх бүхий байгууллагуудаас зөвшөөрөл авч данснаас хасах зөвлөмж өгсөн. Актлаж, данснаас хасах саналыг аймгийн ОНӨГ-т хүргүүлж шийдвэрийн дагуу зөрчлийг арилгаж, зөвлөмжийг 100 хувь биелүүлсэн байна.

Хүснэгт 3. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | /мянган төгрөгөөр/ Биелэлт | | |
|-----------------|------------------------|------------------|-------------------------------|------------------|------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 744.2 | 1 | 744.2 | 100 |
| Зөвлөмж | 2 | 190,529.1 | 2 | 190,529.1 | 100 |
| Нийт дүн | 5 | 191,273.3 | 2 | 191,273.3 | 100 |

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар аливаа акт, албан шаардлага хүргүүлэх асуудлууд илрээгүй бөгөөд программын шинэчлэлтэй холбоотойгоор хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийг анхны өртгөөс илүү тооцож тайлагнасныг ашиглах жилийн дагуу бодолт хийлгэж залруулсан ба шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж өглөө.

5.1 Алдааны залруулга

Илрүүлэлт: Хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл нь анхны өртгөөсөө 8,612.5 мянган төгрөгөөр илүү тооцож тайлагнасан нь үндсэн хөрөнгийн үлдэгдэл болон санхүүгийн тайланг буруугаар илэрхийлсэн алдаа байна.

Залруулга: Илрүүлэлтийн дагуу алдааг шалгахад программын шинэчлэлтэй холбоотойгоор үүссэн байсныг тогтоож, ашиглах жилийн дагуу бодолт хийлгэж, хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийг зөв болгож алдааг залруулав.

5.2 Зөвлөмж

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 онд нийт 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулахаас 94

